

I. ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Байгууллагын нэр: _____ Регистрийн №: _____

Утасны дугаар: _____ И-мэйл хаяг: _____

Захирлын овог, нэр: _____ Регистрийн №: _____

Гар утасны дугаар: _____ И-мэйл хаяг: _____

II. ХАРИЛЦАХ ДАНС НЭЭХ

Валютын төрөл: Төгрөг () Ам.доллар () Юань () Евро () Бусад _____ ()

Дансны төрөл: Харилцах данс () Хугацаатай хадгаламжийн данс _____ сар ()

III. ЦАЛИН ОЛГОХ ҮЙЛЧИЛГЭЭ Үйлчилгээнд бүртгүүлэх

IV. ТИ ДИ БИ ОНЛАЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Багцын төрөл:

Онлайн (дансны лавлагаа, үйлчилгээний хүсэлт илгээх)

Онлайн Плас (нэг удаагийн нууц үг /OTP/ үүсгэх апп эсвэл VASCO)

Онлайн Премиум (нууцлалын төхөөрөмж /VASCO/ ашиглана)

ТИ ДИ БИ Онлайн үйлчилгээнд бүртгүүлэх нэвтрэх нэр:

Үйлчилгээнд холбох дансны дугаар:

Банканд бүртгэлтэй бүх дансыг холбох

Зөвхөн дараах дансыг холбох

1. _____

2. _____

3. _____

№	Нэвтрэх нэр	Нэвтрэх нэрийг ашиглах ажилтны овог нэр	Эрхийн төрөл			Гүйлгээ зөвшөөрөх зэрэглэл	Утас	Гүйлгээний мэдээлэл авах и-мэйл
			Лавлагааны эрх	Гүйлгээний эрх	Гүйлгээ зөвшөөрөх эрх			
1								
2								
3								
4								

V. МЕССЕЖ БАНК ҮЙЛЧИЛГЭЭ

Утасны дугаар: _____

И-Мэйл хаяг: _____

Үйлчилгээнд бүртгүүлэх*:

Мэдэгдэл авах хэл Монгол Англи

*** САНАМЖ: Үйлчилгээнд бүртгүүлснээр банканд дахь СОНГОСОН дансныхаа 5,000 болон түүнээс дээш төгрөгийн гүйлгээнүүдэд мэдэгдэл авч гүйлгээ тус бүрт холбогдох шимтгэлийг төлөхийг зөвшөөрч байна.**

Зарлага гарах боломжгүй дансны хувьд шимтгэл суутгах дансаа бичнэ үү (жишээ нь: хугацаатай хадгаламж): _____

Үйлчилгээнд холбох дансны мэдээлэл:

Банканд бүртгэлтэй БҮХ дансны орлого, зарлагын мэдэгдэл авах

133133 тусгай дугаарт мессеж илгээн дансны үлдэгдэл шалгах:

№	Дансны дугаар	Дансыг төлөөлөх тоо (1-999)
1		
2		
3		
4		

№	Зөвхөн дараах дансыг холбох	Мэдэгдлийн төрөл	
		Орлого	Зарлага
1			
2			
3			

VI. И-БИЛЛИНГ ҮЙЛЧИЛГЭЭ

Биллериийн нэр: _____ Хэрэглэгчийн дугаар: _____ Лимит: _____
Хугацаа: _____ жил Шимтгэл суутгах данс: _____ Баримт хүлээн авах и-мэйл: _____

VII. ТӨВЛӨРҮҮЛЭХ ШИЛЖҮҮЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ Үйлчилгээнд бүртгүүлэх

Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл болон холбогдох гэрээний нөхцөлтэй танилцаж, зөвшөөрөв.

Харилцагчийн баталгаат
гарын үсэг: _____
Овог, нэр: _____
Албан тушаал: _____
Огноо: _____

Тамга

БАНКНЫ ХЭРЭГЦЭЭНД

Бүртгэсэн ажилтан: _____
Овог, нэр _____ *Теллер дугаар* _____ *Гарын үсэг* _____ Огноо:

Хянасан ажилтан: _____
Овог, нэр _____ *Теллер дугаар* _____ *Гарын үсэг* _____ Огноо:

Дансны дугаар:

Customer ID (CIF): _____

I. CUSTOMER INFORMATION

Company's name: _____ Registration №: _____
 Phone number: _____ E-mail address: _____
 CEO's name: _____ Registration №: _____
 Phone number: _____ E-mail address: _____

II. CURRENT ACCOUNT

Currency type: MNT () USD () CNY () EUR () Other _____ ()
Account type: Current account () Term deposit _____ months ()

III. SALARY ACCOUNT SERVICE

Register service

IV. TDB ONLINE SERVICE

TDB ONLINE packages:
 Online (balance inquiry)
 Online Plus (with OTP or VASCO)
 Online Premium (with VASCO)

Add accounts on TDB Online:
 Add all accounts
 Add selected accounts:
 1. _____
 2. _____
 3. _____

TDB ONLINE User ID:

№	User ID	Employee, who will use User ID	Type of authority			Approval rank	Notification phone number	Notification e-mail
			Balance inquiry	Make transactions	Approve transactions			
1								
2								
3								
4								

V. MESSAGE BANKING

Mobile number: _____
 E-mail address: _____

Register service *:
 Language Mongolian English

** NOTE: By registering this service, you are agreeing to pay the fees from transactions in amount of 5000 MNT or higher and to receive transaction information.*

Please write on account number, which enquires the fees for nondeductible accounts (For example: Term deposit): _____

Account information to link to service:

Connect ALL accounts transaction types

Balance inquiry send message to 133133

№	Selected account number	Transaction type	
		Income	Withdrawal
1			
2			
3			

№	Account number	Number to represent account (1-999)
1		
2		
3		
4		

VI. E-BILLING

Billers name: _____ **User ID:** _____ **Limit:** _____
Period: / _____ year / **Account will be debited:** _____ **Notification E-mail :** _____

VII. SWEEP TRANSFER SERVICE **Register service**

I confirm that the information above is correct, terms of agreement, fees and commissions of services are accepted.

Customer's authorized signature: _____
Full name: _____
Position: _____
Date: _____

Stamp

BANK USE ONLY

Recorded by: _____ *Name* _____ *Teller code* _____ *Signature* _____ **Date:**

Revised by: _____ *Name* _____ *Teller code* _____ *Signature* _____ **Date:**

Account number:

ТИ ДИ БИ ОНЛАЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГЭРЭЭ
(Хуулийн этгээд)

_____ оны _____ - р сарын _____ - ны өдөр Дугаар . . .

Энэхүү **ТИ ДИ БИ онлайн үйлчилгээний гэрээ** (цаашид “**Гэрээ**” гэх) - г Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг тус тус үндэслэн нэг талаас 14210 Энхтайваны өргөн чөлөө 19, Сүхбаатар дүүргийн 1-р хороо, Улаанбаатар, Монгол Улс хаягт орших Худалдаа, хөгжлийн банк (цаашид “**Банк**” гэх) нөгөө талаас _____ хаягт орших _____

(регистрийн дугаар _____) (цаашид “**Харилцагч**”, хамтад нь “**Талууд**” гэх) нар дараах нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Гэрээний зүйл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь банк ТИ ДИ БИ онлайн банкны үйлчилгээ (цаашид “**Ти Ди Би Онлайн Үйлчилгээ**” гэх) - ний эрхийг харилцагчийн хүсэлтийн дагуу нээж, интернэт холболт бүхий мэдээллийн технологи, харилцаа холбооны төхөөрөмж (гар утас, компьютер, таблет гэх мэт) ашиглан, www.ebank.mn цахим хуудсаар дамжуулан, өөрийн Худалдаа, хөгжлийн банкин дахь харилцах, хадгаламж, карт, зээл, зээлийн картан данс (цаашид “данс” гэх) - анд хандаж банкны үйлчилгээг авахыг хүссэн харилцагчдад уг үйлчилгээг үзүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Харилцагч нь Ти Ди Би Онлайн үйлчилгээг ашиглан өөрийн сонгосон багцаас хамааран Банкны үйлчилгээ авах боломжтой ба тухайн сонгосон Ти Ди Би Онлайн багцын үйлчилгээний талаарх (ямар эрхтэй, ямар үйлчилгээ авах боломжтой гэх мэт) мэдээллийг Банкны www.tdbm.mn цахим хуудсын бүтээгдэхүүний танилцуулга хэсгээс шинэчлэгдсэн байдлаар авна.

1.3. Харилцагчийн Ти Ди Би онлайн үйлчилгээнд бүртгүүлэх нэвтрэх нэр, болон холбох дансуудыг харилцагчийн хүсэлтийн дагуу банк бүртгэх ба харилцагч өөрөө зайнаас дээрх мэдээллээ өөрчлөх боломжтой байна.

1.4. Ти Ди Би Онлайн үйлчилгээнд харилцагчийг таних, гүйлгээний зөвшөөрлийг батлах болон Харилцагч болон банкны эрсдэлээс хамгаалах зорилгоор нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, нэг удаагийн нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үг гэсэн нууцлалын элементүүдийг хослуулан багц бүрт ялгаатайгаар ашиглана. Үүнд:

д/д	Багцын нэр	Нууцлалын элементүүд			
		Нэвтрэх нэр	Нэвтрэх нууц үг (олон хэрэглэгдэх)	Нэвтрэх нууц үг (нэг удаагийн)	Гүйлгээний нууц үг
1.	Онлайн	√	√		
2	Онлайн плас	√	√	√	√
3	Онлайн премиум	√	√	√	√

1.5. Дээрх хүснэгтэд заасны дагуу Онлайн багцын харилцагчийн хувьд түүний нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг нь, Онлайн плас, Онлайн премиум, багцын харилцагчийн хувьд нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үг болон нэг удаагийн нууц дугаарууд нь тухайн харилцагчийн банкин дахь мөнгөн хөрөнгийг захиран зарцуулахад хэрэглэгдэх албан ёсны баталгаат тэмдгийн дардас, мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээдийн баталгаат гарын үсгийн маягийн адил хүчин төгөлдөр байна. Энэхүү зарчим нь харилцагчийн сонгосон багцын хүрээнд банкнаас авч байгаа бусад үйлчилгээнүүдэд мөн адил хамаарах болохыг Талууд үүгээр зөвшөөрөв.

1.6. Харилцагч нь нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үг, нэг удаагийн нууц дугаар зэргийг ашиглан Ти Ди Би онлайн үйлчилгээгээр дамжуулан гүйлгээ хийх тохиолдолд банк харилцагчийн данснаас уг гүйлгээний дүнгээр хасалт хийх болохыг талууд харилцан зөвшөөрөв.

1.7. Харилцагчид 24 цагийн туршид (төлөвлөгөөт засвар үйлчилгээний цагт үйлчлэхгүй) Ти Ди Би Онлайн үйлчилгээг хүлээн авах, хийх боломжтой бөгөөд хэлцэлтэй арилжааны гүйлгээ нь зөвхөн ажлын өдөр, ажлын цагуудад хийгдэнэ.

1.8. Харилцагч нь Ти Ди Би Онлайн үйлчилгээний дагуу авсан үйлчилгээний шимтгэлийг банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасны дагуу энэхүү үйлчилгээнд холбоотой данс болон харилцагчийн банканд дахь бусад данснаас суутган авахыг үүгээр хүлээн зөвшөөрч байна.

1.9. Бэлэн бус ханшаар хийгдсэн гүйлгээг харилцагчийн хүсэлтээр буцаах тохиолдолд тухайн үеийн банкны зарласан бэлэн бус ханшаар хийнэ.

1.10. Гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байгаа Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл болон түүнд цаашид орох нэмэлт, өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг болно.

1.11. Банкнаас харилцагчид худалдсан нууцлалын төхөөрөмжийн баталгаат хугацаа нь харилцагчтай төхөөрөмж хүлээлцсэн акт үйлдсэн өдрөөс хойш 1 жил байна.

Хоёр. Банкны эрх, үүрэг

2.1. Банк нь Харилцагчийн багцын эрхэд нийцүүлэн дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- 2.1.1. Үйлчилгээний талаарх заавар зөвлөмжөөр харилцагчийг хангах;
- 2.1.2. Амжилттай хийгдсэн гүйлгээ бүрийг баталгаажуулж, гүйлгээний баримтыг харилцагчийн банкинд өгсөн имэйл хаягт илгээх;
- 2.1.3. Харилцагчийн хүсэлтээр харилцагчийн дансны тодорхойлолт болон Ти Ди Би онлайн үйлчилгээгээр дамжуулан хийгдсэн гүйлгээний баримт, хуулгыг гаргаж өгөх;
- 2.1.4. Харилцагчийн харилцах данс болон гүйлгээний талаарх мэдээллийг Монгол улсын хууль, тогтоомжид зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, нууцлалыг хадгалах;
- 2.1.5. Харилцагчийн хүсэлтээр хадгаламжийн данс нээж, харилцагч банкны нэгжид биечлэн ирж гэрээ байгуулсны үндсэн дээр зарлагын гүйлгээ гаргах эрхийг нээх;
- 2.1.6. Харилцагчийн хүсэлтийн дагуу арилжааны хэлцэл хийх;
- 2.1.7. Банкнаас харилцагчдад олгож буй бусад нэмэлт үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх;
- 2.1.8. Банк нь “Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл” болон түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг тухай бүр өөрийн www.tdbm.mn цахим хуудсаар дамжуулан харилцагчид хүргэх.

2.2. Банк нь Харилцагчийн багцын эрхэд нийцүүлэн дараах эрх эдэлнэ. Үүнд:

- 2.2.1. Харилцагчийн Ти Ди Би Онлайн үйлчилгээний шимтгэлийг “Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөл” - д заасны дагуу суутгах;
- 2.2.2. Харилцагчийн шимтгэл төлөх дансны үлдэгдэл хүрэлцэхгүй байгаа тохиолдолд түүний эзэмшлийн бусад дансны үлдэгдлийг шалгаж, суутган авах;
- 2.2.3. Гэрээний 2.2.2 дахь заалтад заасны дагуу харилцагчийн эзэмшлийн бүх дансны үлдэгдэл шимтгэл төлөхөд хүрэлцэхгүй буюу боломжгүй байгаа тохиолдолд тухайн харилцагчид үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
- 2.2.4. Үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцлийг өөрийн санаачилгаар өөрчлөн тогтоох;
- 2.2.5. Харилцагч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол гэрээг нэг талын санаачилгаар цуцалж, үйлчилгээний эрхийг хаах;
- 2.2.6. Аливаа маргаантай гүйлгээг шийдвэрлэхийн тулд харилцагчийн дансанд хаалт тавих, битүүмжлэх;
- 2.2.7. Аливаа маргаантай гүйлгээнд харилцагчийн буруутай үйлдэл нотлогдвол түүний данснаас үл маргах журмаар суутган авах;

2.2.8.Харилцагч интернэт банкны үйлчилгээ ашиглах явцад 10 минутын дотор функцын үйлдэл хийгээгүй тохиолдолд харилцагч болон банкныг эрсдэлээс хамгаалах зорилгоор тухайн программаас автоматаар гаргах;

2.2.9.Харилцагч болон банкныг эрсдэлээс хамгаалан, нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үг, нэг удаагийн нууц үгийн аль нэгийг нь 5 удаа буруу оруулсан тохиолдолд Харилцагчийн тухайн нууц үгийг системээс автоматаар блоклох;

2.2.10. Харилцагч банкны буруутай үйл ажиллагаанаас шалтгаалалгүйгээр өөрийн нэвтрэх нэр, нууц үг, гүйлгээний нууц үг, нэг удаагийн нууц үгийг гуравдагч этгээдэд дамжуулсан, задруулсан, алдсаны улмаас түүнд учирсан аливаа хохирлыг банк хариуцахгүй.

Гурав. Харилцагчийн эрх, үүрэг

3.1. Харилцагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.1.1.Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан банкинд илгээх хүсэлтийг үнэн зөв бөглөж өгөх;

3.1.2.Ти Ди Би Онлайн үйлчилгээний зааврыг баримтлах;

3.1.3.Ти Ди Би Онлайн үйлчилгээнд шинээр бүртгүүлэхэд банкнаас шинээр илгээсэн болон үйлчилгээ авах явцдаа банкинд хүсэлт гарган шинэчлүүлсэн нэвтрэх болон гүйлгээний нууц үгүүдээ үйлчилгээнд эхний нэвтрэлтээр тэдгээрийг заавал сольж ашиглах;

3.1.4.Нэвтрэх нууц үг, гүйлгээний нууц үг, нууцлалын төхөөрөмжийг бусдад дамжуулахгүй байх, нууцлалыг хадгалах, задруулахгүй байх, нууцлалыг хадгалаагүйгээс үүсэн гарсан аливаа хохирлыг хариуцах;

3.1.5.Нэвтрэх болон гүйлгээний нууц үгээ бусдад дамжуулсан, задруулсан, алдсан, нууцлалтын төхөөрөмж болон гар утсаа гээсэн, хулгайд алдсан тохиолдолд банкны 24 цагийн лавлах 1900-1977 дугаарын утас, info@tdbmn.mn цахим хаягт банкинд бүртгэлтэй өөрийн цахим хаягнаас электрон шуудан илгээх, эсвэл банкны нэгжид биечлэн ирж мэдэгдэн, үйлчилгээний эрхээ түр хаалгах, мэдэгдээгүйн улмаас үүсэх хохирлыг бүрэн хариуцах;

3.1.6.Банк харилцагчийн нэвтрэх нэр, нууц үгүүдийн талаарх мэдээллийг харилцагчаас авахаар шаардахгүй тул банктай ижил нэр, вэб хаягнаас хандаж байгаа аливаа хүсэлтэд мэдээллээ өгөхгүй байх үүрэгтэй ба үүнээс үүдэн гарсан хохирлыг бүрэн хариуцах. Ийм хүсэлт Танд ирсэн тохиолдолд банкинд нэн даруй мэдэгдэх;

3.1.7.Нэвтрэх болон гүйлгээний нууц үгээ хамгийн багадаа 6- н сар тутам сольж хэвших;

3.1.8.Хэрэв хэн нэгэнд өөрийн дансаа энэхүү үйлчилгээнд хандан захиран зарцуулах эрхийг шилжүүлэх шаардлага гарсан тохиолдолд банкинд энэ тухай хандаж, албан ёсны итгэмжлэлээр шилжүүлэх;

3.1.9.Ти Ди Би Онлайн үйлчилгээг ашиглаж дууссан даруйдаа энэ программаас бүрэн гарч байх, энэ үүргийг дагаагүйгээс болж үүдэн гарах хохирлыг хариуцах;

3.1.10.Ти Ди Би Онлайн үйлчилгээнд ашиглаж буй компьютерийн болон гар утасны интернэтийн төлбөрийг хариуцах;

3.1.11.Нууцлалын төхөөрөмжийг зориулалтын дагуу ашиглах;

3.1.12.Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан хийсэн гүйлгээ бүрийг дансны хуулгатай тухай бүр тулгаж шалгах;

3.1.13.Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр гүйлгээ хийхдээ гүйлгээний мэдээллийг үнэн зөв оруулан, нягталж шалгасны үндсэн дээр уг гүйлгээг хийх;

3.1.14.Харилцагч нь гэрээний хугацаанд харилцах, хадгаламжийн данснаасаа Банкнаас тогтоосон шимтгэл хураамжийг “Банкны үйлчилгээний хүү шимтгэлийн ерөнхий нөхцөл”-д даасны дагуу төлөх;

3.1.15.Харилцагч Ти Ди Би Онлайн үйлчилгээндээ нэмэлт хэрэглэгч бүртгүүлэх, эрхийг нь цуцлуулах, өөрчлөх, хязгаарлах тохиолдолд холбогдох мэдээллийг тухай бүр албан бичгээр Банканд мэдэгдэх ба мэдэгдээгүйгээс үүсэх аливаа эрсдэлийг харилцагч өөрөө хүлээнэ.

3.2. Харилцагч нь өөрийн багцаас хамаарч дараах эрх эдэлнэ. Үүнд:

3.2.1.Үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлтийг банкинд гаргах;

3.2.2.Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан өөрийн данс хооронд, банкны нэгж хооронд, банк хооронд, гадаад шилжүүлэг, багц гүйлгээ, захиалгат шилжүүлгийн гүйлгээ, цалингийн багц гүйлгээ, арилжааны хэлцэл зэрэг бэлэн бус гүйлгээ хийх;

3.2.3.Өөрийн хийсэн гүйлгээний лавлагааг авах;

3.2.4. Мессеж банкны үйлчилгээний хүсэлт илгээх;

3.2.5. Банкнаас нэмэлтээр олгож буй бусад үйлчилгээг авах;

3.2.6. Харилцагч Ти Ди Би Онлайн үйлчилгээндээ нэмэлт хэрэглэгч бүртгүүлэх, эрхийг нь цуцлуулах, өөрчлөх, хязгаарлах эрхтэй.

Дөрөв. Гүйлгээ, төлбөр тооцоо

4.1. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр хийгдэх гүйлгээ, төлбөр тооцооны аюулгүй байдлыг хангах үүднээс банк багц тус бүрийн эрхэд тохируулан дараах хязгаарлалтуудыг тогтооно. Үүнд:

4.1.1.Нэг өдөрт хийх гүйлгээний дүнгийн дээд хэмжээ;

4.1.2.Гар утас, интернэтээр нэвтрэх болон гүйлгээ хийхэд шаарддагддаг нууц үгийг оруулах оролдлогын тоо.

4.1.3.Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр хоёр өөр төрлийн валютын дансны хооронд хийгдэх гүйлгээ нь тухайн үеийн банкнаас зарласан ханшийн шатлалын дагуу бэлэн бус ханш байна.

4.2. Тухайн ажлын өдрийн тасалбар болгох хугацаанд оруулсан гүйлгээ нь тухайн ажлын өдөрт хийгдсэнд тооцох бөгөөд бусад хугацаанд хийгдсэн гүйлгээ нь дараагийн ажлын өдөрт хийгдэнэ.

Энэ хугацаанд хүлээлгэнд байна.

Д/д	Гүйлгээний төрөл	Тасалбар болгох хугацаа (Улаанбаатар хотын цагаар)
1	Өөрийн данс хооронд	Тухайн өдрийн банкны тасалбар болгох хугацаанаас дараа өдрийн тасалбар болгох хугацаа хүртэл*
2	Банк доторх	
3	Банк хоорондын бага дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журамд тусгасан “бага дүнтэй гүйлгээ”	
4	Банк хоорондын их дүнтэй гүйлгээний төлбөр тооцооны журамд тусгасан “их дүнтэй гүйлгээ”	Ажлын өдрийн 09:00 – 15:30 хооронд

*Банкны тасалбар болгох хугацаа нь 00:00 цагаас 04.00 цагийн хооронд байна.

4.3. Захиалгат шилжүүлгийн гүйлгээ болон хэлцэлтэй арилжааны гүйлгээ хийх өдөр нь ажлын бус өдөр таарвал дараагийн ажлын өдөрт хийгдэнэ.

4.4. Тухайн шилжүүлэх дансны цахим төлбөрийн даалгаврын өгөгдлийг бүрэн шивсэн, данс дахь үлдэгдэл нь тухайн дүн болон холбогдох шимтгэлийг төлөхөд хүрэлцэж байгаа тохиолдолд гүйлгээ хийгдэнэ.

4.5. Тухайн дансаарх гүйлгээ нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, үүнтэй холбоотой хууль тогтоомжийн акт болон банкны бодлого, журмын дагуу эрсдэлтэй буюу сэжигтэй гүйлгээнд тооцогдож байгаа, эсхүл тухайн дансанд Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу битүүмж тавьсан зэрэг тохиолдолд гүйлгээ шилжихгүй.

4.6. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр хийгдсэн гүйлгээтэй холбоотой маргааныг гүйлгээ хийгдсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор бичгээр гаргах боломжтой. Үүнээс хугацаа хэтэрсэн маргааныг банк хүлээн авахгүй.

Тав. Гэрээний хугацаа ба гэрээ цуцлах

- 5.1. Харилцагч гэрээг цуцлах хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд цуцлах хүртэл, эсвэл банкны хүү, шимтгэлийн ерөнхий нөхцөлд заасны дагуу төлөх ёстой шимтгэл, хураамжийг төлөх хүртэл гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.2. Банк, эсвэл харилцагчийн аль нэг талын санаачилгаар үйлчилгээний эрхийг зогсоосноор энэхүү гэрээний хугацааг дуусгавар болсонд тооцно.
- 5.3. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд банк нь хуанлийн 30 хоногийн өмнө харилцагчид мэдэгдэх ба мэдэгдэл хүргүүлснээс хойш 10 хоногийн дотор Банканд гэрээ нэмэлт, өөрчлөлтийн талаар холбогдох хүсэлтийг ирүүлээгүй тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсон талаар Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр мэдээнэ.

Зургаа. Харилцагчид

- 6.1. Талуудын аль нэг нь гэрээг зөрчснөөс нөгөө талдаа учирсан бодит хохирол, зардлыг гэрээг зөрчсөн тал бүрэн хариуцна.
- 6.2. Гэрээ нь цуцлагдсан, дуусгавар болсон тохиолдолд гэрээг хүчин төгөлдөр байх үед үүссэн төлбөр тооцооны эрх, үүрэг нь бүрэн биелэгдэж дуусах хүртэл хугацаанд гэрээний зохицуулалт нь талуудын хувьд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 6.3. Харилцагч гэрээний 3.1 - д заасан үүргүүдийг биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг өөрөө бүрэн хариуцна.
- 6.4. Ти Ди Би Онлайн үйлчилгээ нийлүүлэгч байгууллага болон үүрэн телефон операторын буруутай үйл ажиллагаа болон харилцагч үйлчилгээний вэб хуудсанд холбогдоход сүлжээний саатал, эсвэл харилцагчийн холбогдож буй компьютер, гар утсанд байрлаж буй программ, вирус зэргээс үүдэн харилцагчид үүссэн аливаа хохирлыг банк хариуцахгүй.
- 6.5. Ти Ди Би Онлайн үйлчилгээнд холбогдоход аль болох нийтийн сүлжээ, төхөөрөмжийг ашиглахгүй байхыг банк сануулж байгаа бөгөөд үүнээс үүдэн гарах хохирлыг банк хариуцахгүй.
- 6.6. Харилцагч гүйлгээний мэдээллийг буруу оруулж гүйлгээ хийсний улмаас харилцагчид үүссэн хохирлыг банк хариуцахгүй.

Долоо. Бусад зүйл

- 7.1. Гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, гэрээг цуцалснаар буюу гэрээний нөхцөл бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.
- 7.2. Гэрээнд шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг талууд харилцан тохиролцож, нэмэлт гэрээ байгуулсаны үндсэн дээр шийдвэрлэнэ.
- 7.3. Ти Ди Би Онлайн үйлчилгээгээр дамжуулан харилцагч өөрийн нэвтрэх нэр, нэвтрэх нууц үг, нэг удаагийн нууц үгийг ашиглан, банкнаас санал болгож буй гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах нөхцөл, бүтээгдэхүүнтэй холбоотой гэрээний төслийг зөвшөөрсөн үйлдэл хийснээр уг нэмэлт гэрээнд гарын үсэг зурсантай ижил хүчин төгөлдөрт тооцно.
- 7.4. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх журмаар шийдвэрлэх ба зөвшилцөж эс чадвал маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 7.5. Гэрээг хоёр хувь үйлдэж, талууд тус бүр нэг хувийг хадгалсан нь хууль зүйн хувьд адил хүчинтэй.

Гэрээ байгуулсан:

Банкийг төлөөлж:

Банкны нэгжийн БМА

(овог, нэр)

(гарын үсэг)

(Тэмдэг)

Харилцагчийг төлөөлж:

(овог, нэр)

(1 - р гарын үсэг)

(2 - р гарын үсэг)

(Тамга)